

20/50



ГҮЙЦЭТГЭГЧ

“БДЗ” ХХК-ИЙН



**СУИС-ИЙН ХИЧЭЭЛИЙН БАЙРНЫ КОРИДОР, АНГИ ТАНХИМЫН ЗАСВАР
ЗАСВАРЫН АЖЛЫН ГЭРЭЭ**

Дугаар № СУИС/202001003

Улаанбаатар хот

Нэг талаас *Соёл, урлагийн их сургууль* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “БДЗ” ХХК (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь СУИС-ийн хичээлийн байрны коридор, анги танхимын засвар, СУИС/202001003 -г (цаашид “ажил” гэх) 96,109,192.00 /*ерэн зургаан сая нэг зуун есөн мянга нэг зуун ерэн хоёр*/ төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: 96,109,192 төгрөг.

Үүнээс: Өөрийн хөрөнгө: 2020 онд	96,109,192 төгрөг.
Засварын зардал	91,226,335 төгрөг
Магадалшгүй ажлын зардал	1,641,428 төгрөг
Захиалагчийн хяналтын зардал	1,641,429 төгрөг
Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	1,600,000 төгрөг

4. Гүйцэтгэгч нь Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороонд байршилтай ажлын даалгаварт заасан талбай бүхий СУИС-ийн хичээлийн төв байрны коридор, анги танхим, мөн Чингэлтэй дүүрэг, 4-р хороонд байршилтай хичээлийн 3 дугаар байрны анги танхимын засварын ажлыг 2020 оны 7 дугаар сарын 30-ны өдөр эхэлж, 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг;
- 5.3. Үнийн санал;
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.


Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

Гэрээ байгуулсан талууд:

Захиалагч талыг төлөөлж:

СУИС-ийн Хяналт-шинжилгээ,
хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал

..... /Г.Сүхбат/


Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
6 дугаар хороо, СУИС-ийн Төв байр.

Утас: 11-325205

Регистрийн дугаар: 5041775

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

“БДЗ” ХХК-ийн инженер

..... /Б.Золжаргал/


Хаяг: Дархан уул аймаг, Дархан сум, 13 баг,
3 байр, 72 тоот

Утас: 99996694

Регистрийн дугаар: 4254619

Харилцагч банкны нэр: Голомт банк

Дансны дугаар: 4305111532